

**БСБ ФИНАНС ББСБ**  
**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО**

1. “БСБ Финанс ББСБ” ХХК нь Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд дараах бодлогыг баримтална. Үүнд:
  - Харилцагчид үзүүлж буй цахим санхүүгийн үйлчилгээндээ Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
  - Харилцагч болон хамтран ажиллагч байгууллагуудтай хамтарч ажиллахдаа Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
  - Өгөгдөл, мэдээлэл, оюуны өмч, хувь хүний мэдээллүүд нь үнэ цэнэ агуулсан хөрөнгөд тооцогдох бөгөөд зөвшөөрөлгүй нэвтрэлт, өөрчлөлт болон устах, эвдрэх, алдагдах зэрэг болзошгүй эрсдэлээс хамгаалагдсан байна.
  
2. Дараах зорилтуудыг биелүүлэхийг зорин ажиллаж байна.
  - Зорилт 1:** Бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа зориулсан Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмуудыг боловсруулж, мөрдлөг болгон ажиллах, тогтмол хянаж, шинэчлэн сайжруулах;
  - Зорилт 2:** Зохицуулагч байгууллагуудаас гаргасан заавал дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, гэрээний үүрэг ба нөхцөлд тусгасан аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангаж ажиллах;
  - Зорилт 3:** Бүх шатны ажилтнууддаа Мэдээллийн аюулгүй байдлын талаарх суурь ойлголтуудыг эзэмшүүлэх;
  - Зорилт 4:** Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг ажилтан, харилцагч болон хамтран ажиллагч байгууллагуудад өгч, болзошгүй эрсдэлээс сэргийлэх;
  - Зорилт 5:** Мэдээллийн хөрөнгийн нууцлалтай, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллах, эрсдэлд суурилсан Мэдээллийн аюулгүй байдлын хяналт, үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэх, тогтмол хяналт тавьж гарч болзошгүй эрсдэлийг удирдах;
  - Зорилт 6:** Мэдээллийн ангилалд үндэслэн мэдээллийн хөрөнгийг бүртгэх, ашиглах, дамжуулах, устгах үйл явцыг аюулгүй хэрэгжүүлэх, хяналт тавих;
  - Зорилт 7:** Харилцагч болон хамтрагч байгууллагын хүлээлт, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах;
  - Зорилт 8:** Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил *Мэдээлэл задруулах, халдлагад өртөх, луйвар гарах, гэнэтийн осол, давагдашгүй хүчин зүйлс гэх мэт тохиолдол* гарах үед үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах бөгөөд тайлагналын механизмыг хэрэгжүүлж, ирээдүйд дахин давтагдахаас сэргийлж, үндсэн шалтгаанд дүн шинжилгээ хийх, арга хэмжээ авах;